

ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААН СЭТГҮҮЛД БҮТЭЭЛ НИЙТЛҮҮЛЭХ ҮЛГЭРЧИЛСЭН ЗААВАР

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү үлгэрчилсэн заавраар “ЭМШУ” сэтгүүлд нийтлүүлэх өгүүлэл, тойм өгүүлэл, эмнэлзүйн ховор тохиолдол, тайлбар өгүүлэл зэргийн хэлбэржүүлэлтийг (формат) зохицуулах ба бүтээлээ ирүүлэхдээ энэхүү зааврыг мөрдөнө.
- 1.2. Судалгааны өгүүлэл нь анагаах ухаан, био-анагаах, уламжлалт анагаах ухаан, нийгмийн эрүүл мэнд, нүүр ам судлал, эм зүй, сувилахуй, анагаах ухааны боловсрол судлал зэрэг салбарын алинд хамаарагдахыг өгүүллийн нэрний доор бичнэ.

Хоёр. Бүтээлд тавигдах ерөнхий шаардлага

2.1. Эрдэм шинжилгээний өгүүлэл.

- 2.1.1. Эрдэм шинжилгээний өгүүллийг өөрийн хийсэн судалгааны ажлын үр дүнд үндэслэн бичсэн байна.
- 2.1.2. Сэтгүүлийн хэвлэмэл хувилбарт нийтлэгдэх бүтээлийн үгийн тоо 4000-аас илүүгүй байна. (Үүнд товч утга, талархал, ном зүй, хүснэгт, зураг, тэдгээрийн нэр, дугаарлалт орохгүй болно).
- 2.1.3. Эрдэм шинжилгээний өгүүлэл нь судалгааны ёс зүйг зөрчөөгүй байхыг шаардах ба судалгааны ёс зүйн зөвшөөрөл авсан тухайг аргазүйн хэсэгт (протоколын дугаар) товч тусгасан байна. (Монгол, Англи)

2.2. Эрдэм шинжилгээний өгүүллийн бүтэц

- 2.2.1. Өгүүллийн нэр
- 2.2.2. Зохиогчдын овог нэр, улсын нэр (гадаадын судлаач бол), байгууллагын нэр, цахим шуудангийн хаяг, харилцах утасны дугаар
- 2.2.3. Товч утга (2.3.6 болон 2.3.7-оос тус тус харах)
- 2.2.4. Түлхүүр үг: Эрдэм шинжилгээний өгүүллийн гарчигт ороогүй нийт таван (5) үгийг Монгол товч утга хэсгийн дараа догол мөрнөөс бичнэ. (2.3.8-аас харах)
- 2.2.5. Үндэслэл: Судалгааны ач холбогдол, онцлог, сэдвийн судлагдсан байдал, судалгааны таамаглал, онолын үндэс зэргийг тусгана.
- 2.2.6. Зорилго: Судалгааны ажлын зорилгыг тодорхой бичнэ.
- 2.2.7. Арга, аргачлал: Судалгаа, шинжилгээ, тэдгээрийн үр дүнгийн боловсруулалтанд ашигласан аргууд зэргийг тусгана)
- 2.2.8. Үр дүн (Тухайн судалгаа шинжилгээ, тэдгээрийн үр дүнг тусгасан байна)
- 2.2.9. Хэлцэмж: Тухайн судалгаа, эрдэм шинжилгээний ажилтай ойролцоо буюу ижил төстэй чиглэлээр хийгдсэн дотоодын болон гадаадын судлаачдын бүтээлүүдийн үр дүнтэй өөрсдийн судалгааны ажлын үр дүнгийн адил төстэй болон ялгаатай байдлуудыг харьцуулан жишиж товч дүгнэх хэлбэрээр бичих ба эшлэл авсан номзүйн дугаарыг эшлэл

өгүүлбэрийн төгсгөлд бичнэ.

2.2.10. Дүгнэлт, санал, зөвлөмж: дүгнэлт нь тухайн судалгаа, эрдэм шинжилгээний ажлын зорилго, зорилттой яв цав тохирсон байдлаар буюу агуулга хэлбэрийг нийцүүлж бичнэ.

2.2.11. Номзүй: (2.7-хэсгээс харах)

2.2.12. Abstract: 2.3.6 болон 2.3.7 хэсгүүдээс харах

2.2.13. Key words: 2.3.8 хэсгээс харах

2.3. Эрдэм шинжилгээний өгүүллийн хэлбэржүүлэлт

2.3.1. Эрдэм шинжилгээний өгүүллийг *.doc өргөтгөлтэй, Arial фондоор, A4 (210x297 mm) хэмжээтэй цаасны 5-10 нүүрт багтаан бичих ба header, footer болон endnotesкомандыг ашиглахгүй, хуудасны дугаарыг тавихгүйгээр бичнэ.

2.3.2. Эрдэм шинжилгээний өгүүллийн бичлэгийн мөр хоорондын зай 1.5 (Line spacing-1.5), догол мөрөөс эхлэх хэсэг бүрийн өмнө 6 pt (before spacing) хэмжээтэй байна.

2.3.3. Бичвэр цаасны зүүн захаас 2.2 см, баруун захаас 2.5 см, дээд, доод талаас тус бүр 2.5 см хэмжээтэй байна (Left: 2.2 cm, Right: 2.5 cm, Top: 2.5 cm, Bottom 2.5cm).

2.3.4. Өгүүллийн нэр 14 pt үсгийн өндөртэй, **bold** форматаар мөр голлон бичих ба Sentence case байна (CapsLk командыг ашиглахгүй). Дэд гарчгууд (хураангуй, түлхүүр үг, удиртгал, үндсэн хэсэг, ном зүй г.м) нь 12pt үсгийн өндөртэй, **bold** форматаар зүүн тал руу зэрэгцүүлэн (align left) бичнэ.

2.3.5. Зохиогчдын овог, нэр нь 10 pt үсгийн өндөртэй, **bold** форматтай, баруун тал руу зэрэгцүүлсэн (align right) байна. Зохиогчдын тухай мэдээлэл оруулахдаа овог, нэрийн баруун дээд өнцөгт тоогоор тэмдэглэж (superscript команд ашиглах) ¹түүний доод мөрнөөс мэдээллийн дэлгэрэнгүйг бичих ба мэдээллийн өмнө харгалзах дугаарыг бичнэ. *Жишээ нь: Ш.Баяр¹ 1 АШУУИС.*

Улс, байгууллагын нэр, цахим шуудангийн хаягийг шинэ мөрнөөс 10pt үсгийн өндөртэй, *Italic* форматтайгаар баруун тал руу зэрэгцүүлэн (align right) бичнэ.

2.3.6. **Товч утга** гэсэн нэр томъёо нь 10pt үсгийн өндөртэй, **Bold**, зүүн тал руу зэрэгцүүлэн (align left) байдлаар бичих ба товч утгын бичвэрийг 11pt үсгийн өндөртэйгөөр regular форматаар, хоёр талдаа тэгшилсэн (justified) байдлаар бичнэ. Монгол товч утгыг 40 хүртэлх мөр, 500-аас багагүй үгэнд багтаасан байвал зохино.

Монгол товч утгыг өгүүллийн эхэнд буюу удиртгалын өмнө талд (Өгүүллийн нэр, Зохиогчдын овог нэр, улсын нэр (гадаадын судлаач бол), байгууллагын нэр, цахим шуудангийн хаяг, харилцах утасны дугаар зэрэг заавал бичигдэхийг анхаарах)

2.3.7. Англи товч утгыг өгүүллийн эцэст буюу ном зүйн дараа байршуулан бичнэ. Англи товч утгыг 40 хүртэлх мөр, 500-аас багагүй үгэнд багтаасан байвал зохино. (Өгүүллийн нэр, Зохиогчдын овог нэр, улсын нэр (гадаадын судлаач бол), байгууллагын нэр, цахим

шуудангийн хаяг, харилцах утасны дугаар зэргийг Англи хэл дээр заавал бичигдэхийг анхаарах)

- 2.3.8. **Түлхүүр үг** гэсэн нэр томьёо нь 12pt үсгийн өндөртэй, **bold**, зүүн тал руу зэрэгцүүлэн (align left) бичнэ. Түлхүүр үгийн бичвэрийг regular форматаар 12pt үсгийн өндөртэйгөөр бичих ба ганц тоон дээр өгүүллийн нэрд орсон үгийг оруулахгүйгээр 4-5 үг ашиглан бичнэ. Монгол хэл дээрх түлхүүр үгийг Монгол товч утгын ард, Англи хэл дээрх түлхүүр үгийг Англи товч утгын ард тус тус байршуулан бичнэ.
- 2.3.9. Өгүүллийн удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, санал, зөвлөмж, ном зүй гэсэн нэр томьёо нь 12pt үсгийн өндөртэй, **bold**, зүүн тал руу зэрэгцүүлсэн (align left) байх ба бичвэр нь нэг (1) баганаар, 12pt үсгийн өндөртэй, хоёр талдаа тэгшилсэн (justified) байдлаар бичнэ.
- 2.3.10. Өгүүллийн үндсэн хэсгийг бүлэг, дэд бүлгүүдэд хуваах ба гарчиг нь 12pt үсгийн өндөртэй, **bold** форматтай, зүүн тал руу зэрэгцүүлэн (align left) харин бичвэрийг нэг (1) баганаар, 12pt үсгийн өндөртэй, хоёр талдаа тэгшилсэн (justified) байдлаар бичнэ.
- 2.3.11. Өгүүлэлд оруулсан жагсаалтыг тэмдэглэхдээ зүйл бүрийн өмнө зураас (-), эсвэл цэг (□), тодруулан заах шаардлагатай бол Англи цагаан толгойн жижиг үсэг (a, b, c), араб тоо (I, II) зэргийг ашиглаж болно.
- 2.3.12. Эрдэм шинжилгээний өгүүлэлд орсон хүснэгт, зураг бүр дугаар, нэр, тайлбартай байх ба бүтээлд орсон дарааллаар дугаарлана.

2.4. Хүснэгтийн бичвэрийн формат

- 2.4.1. Хүснэгтийн дугаар, нэрийг Arial (font) фонттой, тодруулсан (Bold style), 11pt (size) үсгийн хэмжээтэй, хоёр талдаа тэгшилсэн (justified), мөр хоорондын зай 1pt байна. Хүснэгтийн гарчгийн өмнө болон дараа 6 pt зай (before and after space 6 pt) авна.
- 2.4.2. Хүснэгтийн нэгдүгээр эгнээний бүх бичвэр Arial (font) фонттой, тодруулсан (bold style), 11 pt (size) хэмжээтэй, зүүн тал руу зэрэгцүүлсэн (align left) байдлаар бичнэ.
- 2.4.3. Хүснэгт доторх бичвэр нь Arial (font) фонттой, ердийн (regular style), 11 pt (size) хэмжээтэй, зүүн тал руу зэрэгцүүлсэн (align left) байдлаар бичнэ.
- 2.4.4. Хүснэгт доторх бичвэрийн мөр хоорондын зай 1pt байх бөгөөд зөвхөн монгол хэлээр бичигдэх ба шаардлагатай нар томьёог гадаад хэлээр оруулсан тохиолдолд нэмэлт тайлбарыг хүснэгтийн дор бичнэ.(2.4.9)
- 2.4.5. Хүснэгт нь зөвхөн 0.5pt өргөнтэй дан шулуун бүхий мөрнөөс тогтсон байх ба босоо баганагүй байна.
- 2.4.6. Хүснэгтийг хуудас дамнуулан бичихгүй ба зурган файл болгохгүй.
- 2.4.7. Тухайн өгүүлэлд байх нийт хүснэгтийн тоо 5-аас хэтрэхгүй байна.
- 2.4.8. Хэрэв хүснэгтийг бусад судлаачийн бүтээлээс хуулбарлан авсан бол мэдээллийн эх сурвалжийг заавал тайлбар хэсэгт бичих ба зохиогчоос хуулбарлах зөвшөөрлийг бичгээр авсан байх шаардлагатай. Тайлбарыг тухайн хүснэгтийн доод хэсэгт шинэ мөрнөөс бичнэ. Хүснэгтийн тайлбар нь Arial (font) фонттой, ердийн regular style), 11 pt (size) хэмжээтэй, хоёр талдаа тэгшилсэн (justified), мөр хоорондын зай 1pt байна.
- 2.4.9. Хүснэгтэд нэмэлт тайлбар шаардсан өгөгдөл орсон тохиолдолд (*, †, ‡, §, ||, ¶, #, **, ††, ‡‡, г.м) тэмдэгтүүдийг ашиглана.

2.5. Зургийн бичвэрийн формат

- 2.5.1. Зурган мэдээлэл гэдэгт бүдүүвч, схем, график, диаграмм, фото зураг зэрэг багтана.
- 2.5.2. Зургийн дугаар, нэр нь зургийн доод хэсэгт байрлах ба Arial (font) фонтоор, тодруулсан (Bold style), 11pt (size) үсгийн хэмжээтэй байна. Зургийн тайлбарыг гарчгийн араас үргэлжлүүлэн бичих бөгөөд Arial (font) фонтоор, хоёр талдаа тэгшилсэн (justified), 11pt (size) үсгийн хэмжээтэй, мөр хоорондын зай 1pt байна.
- 2.5.3. Зургийн тайлбар байхгүй бичвэр үргэлжлэх тохиолдолд зургийн гарчгийн өмнө болон дараа 6 pt зай (before and after space 6 pt)-тай байна.
- 2.5.4. Зураг дээрх гол ойлголтыг сумаар зааж зургийн хэмжээсийг загвар зургийн дагуу тэмдэглэсэн байна. Зураг/диаграммд бичигдэх үсгийн фонтын хэмжээ 8-10 pt байна. Зургийн тайлбар дугаарыг үсгээр бичнэ.
- 2.5.5. Тухайн өгүүлэлд байх зургийн нийт тоо хэмжээ 8-аас ихгүй байх бөгөөд 600dpi нягтралтайгаар JPEG эсвэл TIF өргөтгөлтэйгөөр тусад нь илгээнэ.
- 2.5.6. График зураг оруулах тохиолдолд гурван хэмжээст бус энгийн байдлаар бэлтгэн оруулах ба plot area-д ямар нэг шугам болон background хийхгүй.

2.6. Талархал

- 2.6.1. Талархал хэсэгт тухайн судалгааны ажил, эрдэм шинжилгээний өгүүлэл зэрэгт нэр нь дурдагдаагүй боловч уг судалгааны ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлсэн, хамтран ажилласан байгууллага, хувь хүн зэрэгт талархал илэрхийлэн бичих ба шаардлагатай гэж үзвэл төслийн дугаарыг бичиж болно.

2.7. Ном зүйн жагсаалтын бичвэрийн формат

- 2.7.1. Энэ хэсэгт ашигласан ном, зохиол, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, бүтээл, сонин, сэтгүүлээс авсан материал, цахим хуудас, видео бичлэг г.м. эх сурвалжийн нэрсийг жагсаан бүтээлийн төгсгөлд буюу англи хураангуйн өмнө хэсэгт бичнэ.
- 2.7.2. Иш татсан бүтээлийн жагсаалт 25-аас илүүгүй байх бөгөөд Arial (font) фонтоор 10 pt хэмжээтэй бичих ба мөр хоорондын зай 1 (single spaced), хуудасны хоёр хажуу талаас тэгш хэлбэрээр (justified margins) бичигдэнэ.
- 2.7.3. Эшлэл болон номзүйн бичилтийг JAMA (AMA)-Journal of American Medical Association загвараар бичнэ. Эшлэлийн эх бичвэрт эшлэсэн дарааллын дагуу бичнэ. Эх бичвэрт эшлэлийн дугаарыг цэгийн дараа зай авахгүйгээр бичнэ.
- 2.7.4. Өмнө нь эшлэл татсан материал дахин тэмдэглэх тохиолдолд уг эшлэлийн анхны дугаарыг давтан тэмдэглэнэ.
- 2.7.5. Дараалсан олон эшлэл авсан тохиолдолд¹⁻³, дараалаагүй олон эшлэл авсан тохиолдолд^{1,5,7,11} гэж тэмдэглэнэ.
- 2.7.6. Бүтээлийн нэрийг зүүн талд зэрэгцүүлэн дараах дарааллын дагуу бичнэ. Үүнд: зохиогчийн нэр, овог, *бүтээлийн нэр (Italic)*, сэтгүүл, боть, хэд дэх хэвлэл, хэвлэсэн хот ба газар, хэвлэгдсэн он, хуудасны дугаар/талыг бичнэ. Copalan A, "WSDM" '21: Proceedings of the 14th ACM International Conference on Web Search and Data Mining. March 2021. Pages 1150-1153, Available: <https://doi.org/10.1145/3437963.3441666>.
- 2.7.7. Веб хаягаас эшлэл авсан тохиолдолд веб эшлэлийн архив

2.8. Хавсралт

- 2.8.1. Судалгааны анхдагч баримт бичиг, эх, тоон үзүүлэлт болон судалгаатай холбоотой бусад мэдээлэл зэргийг үндсэн бичвэрт оруулахгүй шаардлагатай гэж үзвэл тусад нь хавсаргана.
- 2.8.2. Хавсралтыг агуулга тус бүрээр нь араб тоогоор дугаарлана.

3.1. Тойм өгүүлэл

- 3.1.1. Тухайн салбар дахь судалгааны үр дүнгийн агуулгыг гаргаж, салбар хоорондын ач холбогдлыг тайлбарласан 20-иос багагүй өгүүллийг 4000 (Үүнд гарчигт хуудас, товч утга, талархал, ном зүй, хүснэгт, зураг, тэдгээрийн нэр, дугаарлалт орохгүй болно) үгэнд багтааж тоймлон дүн шинжилгээ хийсэн байх ба А4 (210x297 mm) хэмжээтэй цаасны 4-5 нүүрт багтаан бичнэ.
- 3.1.2. Тойм өгүүлэлд байх хүснэгт болон зургийн нийт тоо 8-аас ихгүй байна.

3.2. Тойм өгүүллийн бүтэц.

- 3.2.1. Өгүүллийн нэр
- 3.2.2. Зохиогчдын овог нэр, байгууллагын нэр, цахим шуудангийн хаяг, харилцах утасны дугаар
- 3.2.3. Товч утга
- 3.2.4. Түлхүүр үг
- 3.2.5. Оршил (судалгааны үндэслэл, ач холбогдол, онцлог, сэдвийн судлагдсан байдал, судалгааны таамаглал, онолын үндэс, арга зүй /судалгаа, шинжилгээ, тэдгээрийн үр дүнгийн боловсруулалтанд ашигласан аргууд/ зэргийг тусгана)
- 3.2.6. Үндсэн хэсэг (Тухайн сэдвээр сүүлийн жилүүдэд нийтлэгдсэн 20-иос багагүй эрдэм шинжилгээний бүтээлүүдийг тоймлох)
- 3.2.7. Хэлцэмж
- 3.2.8. Дүгнэлт, санал, зөвлөмж
- 3.2.9. Номзүй
- 3.2.10. Abstract
- 3.2.11. Key words

3.3. Тойм өгүүлэллийн хэлбэржүүлэлт.

- 3.3.1. Тойм өгүүллийг *.doc өргөтгөлтэй, Arial фондоор, А4 (210x297 mm) хэмжээтэй цаасны 5-10 нүүрт багтаан бичих ба header, footer болон endnotesкомандыг ашиглахгүй, хуудасны дугаарыг тавихгүй.
- 3.3.2. Тойм өгүүллийн бичлэгийн мөр хоорондын зай 1.5 (Line spacing-1.5), догол мөрөөс эхлэх хэсэг бүрийн өмнө 6 pt (before spacing) хэмжээтэй байна.
- 3.3.3. Бичвэр цаасны зүүн захаас 2.2 см, баруун захаас 2.5 см, дээд, доод талаас тус бүр 2.5 см хэмжээтэй байна (Left: 2.2 cm, Right: 2.5 cm, Top: 2.5 cm, Bottom 2.5cm).
- 3.3.4. Өгүүллийн гарчгийг том үсгээр, 14pt үсгийн өндөртэй, **Bold** форматаар мөр голлон бичнэ. Дэд гарчгууд (хураангуй, түлхүүр үг, удиртгал, үндсэн хэсэг, ном зүй г.м) нь 12pt үсгийн өндөртэй, **Bold** форматаар зүүн тал руу зэрэгцүүлэн (align left) бичнэ.
- 3.3.5. Зохиогчдын овог, нэр нь 10pt үсгийн өндөртэй, **Bold** форматтай, баруун тал руу зэрэгцүүлсэн (align right) байна. Зохиогчдын тухай мэдээлэл оруулахдаа овог, нэрийн баруун дээд өнцөгт тоогоор тэмдэглэж (superscript команд ашиглах) /^{1/} түүний доод мөрнөөс мэдээллийн

дэлгэрэнгүйг бичих ба мэдээллийн өмнө харгалзах дугаарыг бичнэ.
Жишээ нь: Ш.Баяр¹ АШУҮИС.

Улс, байгууллагын нэр, цахим шуудангийн хаягийг шинэ мөрнөөс 10pt үсгийн өндөртэй, *Italic* форматтайгаар баруун тал руу зэрэгцүүлэн (align right) бичнэ.

- 3.3.6. Хураангуй гэсэн нэр томьёо нь 12pt үсгийн өндөртэй, **Bold**, зүүн тал руу зэрэгцүүлэн (align left) байдлаар бичих ба хураангуйн бичвэрийг 12pt үсгийн өндөртэйгөөр **regular** форматаар бичнэ. Монгол хураангуйг өгүүллийн эхэнд буюу удиртгалын өмнө талд, Англи хураангуйг өгүүллийн эцэст буюу ном зүйн дараа байршуулан бичнэ. Хураангуйг 20 мөр, 300 орчим үгэнд багтаасан байвал зохино.
- 3.3.7. Англи хураангуй дахь өгүүлбэрийн бүтэц, агуулга нь Монгол хураангуй дахь өгүүлэмжтэй явц цав тохирсон байна.
- 3.3.8. Түлхүүр үг гэсэн нэр томьёо нь 12pt үсгийн өндөртэй, **Bold**, зүүн тал руу зэрэгцүүлэн (align left) бичнэ. Түлхүүр үгийн бичвэрийг **regular** форматаар бичих ба ганц тоон дээр өгүүллийн нэрд орсон үгийг оруулахгүйгээр 4-5 үг ашиглан бичнэ. Монгол хэл дээрх түлхүүр үгийг Монгол хураангуйн ард, Англи хэл дээрх түлхүүр үгийг Англи хураангуйн ард тус тус байршуулан бичнэ.
- 3.3.9. Өгүүллийн удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, санал, зөвлөмж, ном зүйн бичвэр нь нэг (1) баганаар, 12pt үсгийн өндөртэй, зүүн тал руу зэрэгцүүлэн (align left) байдлаар бичнэ.
- 3.3.10. Шаардлагатай гэж үзвэл өгүүллийн үндсэн хэсгийг бүлэг, дэд бүлгүүдэд хувааж болох ба гарчиг нь 12pt үсгийн өндөртэй, **Bold** форматтай, зүүн тал руу зэрэгцүүлэн (align left) байдлаар бичнэ.
- 3.3.11. Өгүүлэлд оруулсан жагсаалтыг тэмдэглэхдээ зүйл бүрийн өмнө зураас (-), эсвэл цэг (□), тодруулан заах шаардлагатай бол Англи цагаан толгойн жижиг үсэг (a, b, c), араб тоо (I, II) зэргийг ашиглаж болно.
- 3.3.12. Эрдэм шинжилгээний өгүүлэлд орсон хүснэгт, зураг бүр дугаар, нэр, тайлбартай байх ба бүтээлд орсон дарааллаар дугаарлана.

3.4. Бичвэрийн бусад хэлбэржүүлэлт ЭШӨ-тэй ижил шаардлагатай болно.

4.1. **Эмнэлзүйн ховор тохиолдол нь дараах бүтэц, хэлбэржүүлэлттэй байна**

4.1.1. Эмнэлзүйн ховор тохиолдлын нэр

4.1.2. Зохиогчдын овог нэр, улсын нэр, байгууллагын нэр, электрон шуудангийн хаяг, харилцах утасны дугаар

4.1.3. Товч утга

4.1.4. Түлхүүр үг

4.1.5. Оршил

4.1.6. Үндсэн хэсэг (Ховор тохиолдлыг танилцуулж тайлбарласан өгүүлэмж, зураг, хүснэгт байх)

4.1.7. Хэлцэмж

4.1.8. Дүгнэлт, санал, зөвлөмж

4.1.9. Номзүй

4.1.10. Abstract

4.1.11. Key words

4.2. Бичвэрийн бусад хэлбэржүүлэлт ЭШӨ-тэй ижил шаардлагатай болно.

5.1. **Тайлбар бичиг (Commentary) нь дараах бүтэц, хэлбэржүүлэлттэй байна.**

Тайлбар бичиг нь өнөөгийн цаг үед шинжлэх ухаанд өрнөж буй сонирхолтой

сэдвээр зохиогчдын байр суурийг илэрхийлсэн товч нийтлэл бөгөөд хүснэгт, зураг нийлээд 2-ээс илүүгүй, эшлэл 30-аас илүүгүй байхаар тооцож 2000 үгэнд багтааж A4 (210x297 mm) хэмжээтэй цаасны 5-8 нүүрт багтаан бичнэ.

- 5.2. Тайлбар бичгийн нэр
- 5.3. Зохиогчдын овог нэр, улсын нэр, байгууллагын нэр, электрон шуудангийн хаяг, харилцах утасны дугаар
- 5.4. Товч утга
- 5.5. Түлхүүр үг
- 5.6. Оршил (судалгааны үндэслэл, ач холбогдол, онцлог, сэдвийн судлагдсан байдал, судалгааны таамаглал, онолын үндэс, арга зүй /судалгаа, шинжилгээ, тэдгээрийн үр дүнгийн боловсруулалтад ашигласан аргууд/ зэргийг тусгана)
- 5.7. Үндсэн хэсэг (Тухайн сэдвээр сүүлийн жилүүдэд нийтлэгдсэн 20-иос багагүй эрдэм шинжилгээний бүтээлүүдийг тоймлох)
- 5.8. Хэлцэмж
- 5.9. Дүгнэлт, санал, зөвлөмж
- 5.10. Номзүй
- 5.11. Abstract
- 5.12. Key words

СЭТГҮҮЛИЙН ДАНС: Худалдаа Хөгжлийн Банк: 499406839, Эрүүл Мэндийн Шинжлэх Ухаан Сэтгүүл.

Анхаарах!

Судлаачид бүтээлээ хэвлүүлэхэд 1 нүүр тус бүрт **30000** төгрөг (редакцийн зөвлөлийн гишүүнээр хянан магадлуулсны 10000, хэвлэлийн зардал болох 20000 төгрөг)-ийн хураамжийг тус тус төлнө. Хэвлэлийн зардлыг сэтгүүлийн **“Худалдаа Хөгжлийн Банк”- ны 510004000499406839 дансанд** тушаана (тухайн өгүүлэл хэвлэгдэхээр шийдвэрлэгдсэн тохиолдолд төлбөрөө тушаана уу). Гүйлгээний утга хэсэгт өөрийн нэр, харилцах утасны дугаарыг бичнэ үү!